



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-майл: comsoc@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022 01 28 № 01/1332
танай _____ -ны № _____ -т

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД БӨГӨӨД ЦАХИМ
ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА


Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяа “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлаар томилогдохоор нэр дэвшэн Лхагвасүрэнгийн Энхбатын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

З.ДАШДАВАА



142203002059